



КРЕДИТ
ББСБ

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 2 сарын 19-ний өдөр

Дугаар 2020/

Улаанбаатар хот

2019 оны ногдол ашиг тараах тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.5 дахь хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.12 дахь хэсэг, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 2 сарын 19-ний өдрийн эчнээ санал хураалтын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Ард Кредит ББСБ ХК-ийн 2019 оны жилийн эцсийн цэвэр ашгийн дүнгээс 50% (тавин хувь)-иар буюу 1,184,675,000 (нэг тэрбум нэг зуун наян дөрвөн сая зургаан зуун далан таван мянга) төгрөгийг мөнгөн хэлбэрээр тооцож, нэгж хувьцаанд 4.23 төгрөгийг хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг болгон хуваарилахыг зөвшөөрсүгэй.
2. Ногдол ашиг хүртэх эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2020 оны 4 сарын 8-ны өдрөөр тогтоосугай.
3. Хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилахтай холбоотой төлбөр тооцоог “Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв” ХХК-иар зуучлуулан гүйцэтгүүлж, ногдол ашгийг хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулах замаар 2020 оны 6 сарын 30-ны өдрийн дотор тараасугай.
4. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж, холбогдох гэрээ хэлцэл байгуулж, төлбөр тооцоог хийж гүйцэтгэхийг Гүйцэтгэх захирал (Г.Тэлмэн)-д даалгасугай.
5. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ТУЗ-ийн дэргэдэх Дотоод аудитын хороонд үүрэг болгосугай.

ДАРГА



Ч.ГАНХУЯГ